APS сурагчдын дэмжлэг, амжилтын төлөвлөгөө

# СУРАГЧ БҮР ЧУХАЛ – БҮГД ШИЛДЭГ БАЙХЫН ТӨЛӨӨ

2022-23 оны хувьд *сурагч бүрийг нэр, давуу тал, хэрэгцээгээр нь* мэдэж, амжилт гаргахад нь туслахын тулд сурагчдын мэдээллийг ашиглаж, хэлний мэдлэг, хөгжлийн бэрхшээл, авьяасын хэрэгцээ эсвэл бусад хүчин зүйлийг харгалзан үзэх зорилгыг манай хэлтэс тавьсан.

## БҮХ СУРАГЧ
### Сайн чанарын сургалтад хамрагдана

Бүх сурагч сургалтын өвөрмөц хэрэгцээг нь хангахад чиглэсэн сайн чанарын танхимын сургалтад хамрагдана. Багш нар сурагчдад тусламж дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө гаргахын тулд багаар уулзаж, сурагч бүр ахиц дэвшил гаргахын төлөө хичээлээ тохируулж өөрчилдөг. Бүх ангийн түвшинд багш нарын баг зорилгодоо хүрэхгүй байгаа сурагчдад нэмэлт дэмжлэг үзүүлэхийн тулд өгөгдөл, шаталсан арга барил ашигладаг.

**Сурагчдын 80-85% хувийн хэрэгцээг хангана**

- Хувь хүний давуу тал, хэрэгцээг хангахад чиглэсэн боловсрол
- Олон янз байдалтай, бүхнийг хамруулсан, тухтай орчин
- Шүүмжит, бүтээлч сэтгэлгээ, харилцааны чадварыг хөгжүүлэх даалгавар
- Цөөн сурагчтай үйл ажиллагаа
- Хөгжлийн бэрхшээлтэй, англи хэл сурч буй, гоц авьяастай сурагчдад чиглэсэн тусгай үйлчилгээ
- Нийгэмших, сэтгэл хөдлөлөө илэрхийлж сурах (НСХИС) хичээл, дадлага
- Бататгах, дадлагажих, шаардлагатай бол дахин заах
- Үнэлгээ, ахицын хяналт

1-Р ШАТЛАЛ



## ЗАРИМ СУРАГЧ
### Нэмэлт тусламж авна

Тодорхой чиглэлээр илүү дэмжлэг авах хэрэгтэй сурагч сайн чанарын танхимын сургалтад хамрагдаж, МӨН

**Сурагчдын 10-15% хувьд ийм түвшний дэмжлэг хэрэгтэй.**

+

- Ганцаарчилсан нэмэлт эсвэл цөөн сурагчтай бүлгийн дэмжлэг
- Байнгын ахицын хяналт, үнэлгээ

2-Р ШАТЛАЛ



## ЦӨӨН СУРАГЧ
### Эрчимтэй, урт хугацааны дэмжлэг авах

Ангийн түвшний зорилгоос үлэмж доогуур эсвэл тодорхойлсон чиглэлд илүү эрчимтэй дэмжлэг хэрэгтэй сурагчид сайн чанарын сургалтад хамрагдаж

**Сурагчдын 1-5% хувьд ийм түвшний дэмжлэг хэрэгтэй.**

+

- Шаардлагатай чиглэлээр ганцаарчилсан эсвэл цөөхөн сурагчтай бүлгийн дэмжлэг
- Байнгын ахицын хяналт, үнэлгээ
- Нэмэлт үнэлгээ хийлгэх чиглүүлэг

3-Р ШАТЛАЛ



EVERY STUDENT COUNTS
EXCELLENCE FOR ALL

## *СУРАГЧ БҮРИЙГ НЭР, ДАВУУ ТАЛ, ХЭРЭГЦЭЭГЭЭР НЬ МЭДЭХ*

# EVERY STUDENT COUNTS

### ГЭР БҮЛ ЮУ ХҮЛЭЭЖ БОЛОХ ВЭ

- Ангийн түвшний шалгуур/зорилтыг хангахад манай хүүхдийн гаргаж буй ахиц дэвшлийн тухай мэдээлэл (сурлагын тайлан, үнэлгээний мэдээлэл, байнгын холбоо харилцаа)
- Сурлага эсвэл зан төлөвтэй холбоотой асуудлыг эрт илрүүлэх
- Дүүргийн хэмжээний болон сургуулийн ахиц дэвшлийн өгөгдлийг нийтлэх
- Манай хүүхдийн сурлага эсвэл зан төлөвийн хэрэгцээтэй тохирсон танхимын сургалт, дэмжлэг
- Өгөгдөлд суурилж асуудлыг шийдвэрлэхэд хүүхэд минь хамтран ажиллаж идэвхтэй оролцох
- Зорилтот эсвэл тусгай дэмжлэг үзүүлэхэд манай хүүхдэд хэр нөлөөлж буй талаар өгөх тогтмол санал бодол
- Эцэг эх/асран хамгаалагчтай хамтран Тусгай боловсролын үйлчилгээнд хамруулах чиглүүлэг өгөх
- Эцэг эхтэй харилцах тодорхой арга зам Хүүхдийнхээ багштай эхлэж холбоо барьж, дараа нь сургуулийн бусад мэргэжилтэнтэй ярих.

## APS СУРАГЧДЫН ДЭМЖЛЭГИЙН МӨЧЛӨГ

### 1 ХЯНАЖ ҮНЭЛЭХ

APS танхимд, сургууль дээр, мөн бүхэлд нь **сурагчид юуг мэддэг, юуг хийж чаддаг** болохыг тогтмол хянаж дүгнэдэг. тодорхой дэмжлэг үр дүнтэй буй эсэхийг тодорхойлоход асуумж, үнэлгээг ашигладаг. APS жил бүр **дүүргийн хэмжээний янз бүрийн үнэлгээ** хийдэг.

- Анхан шатны бичиг үсгийн үндсэн ур чадварын динамик үзүүлэлт (АШБҮҮЧДҮ)
- Уншлагын шалгалт (6-9 анги, жилд 3 удаа)
- Тооны шалгалт (1-8 анги, жилд 3 удаа)
- Сургалтын шалгуурын (СШ) шалгалт (3-12 анги)
- Нийгэмших, сэтгэл хөдлөл илэрхийлж сурах асуумж (3-12 анги, жилд олон удаа)
- Авиазүйн мэдлэг Бичиг үсгийн асуумж (PALS)




### 2. ТӨЛӨВЛӨХ

Хэрэгцээ, давуу талд үндэслэн сурагч бүрд заах ажиллагааг төлөвлөхийн тулд багш нар багаар ажиллах Эдгээр төлөвлөгөөнд бүх сурагч, мөн **ТБТ/504 хөтөлбөртэй**, **англи хэл суралцагч, гоц авьяастны ангийн сурагч, өнгөт арьстан сурагч (Хар, Испани/Латин, Ази гаралтай, бусад)**, **дунд боловсролын түвшинд буй сурагчид** нэмэлт/өөр дэмжлэг үзүүлэх зэрэг тусгай дэмжлэг үзүүлж, арга барилаар ажиллах багтана. Эдгээр төлөвлөгөөнд **Нийгэмших, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх** арга зам, мэдээлэл багтана.

### 3 ДЭМЖЛЭГТЭЙ ЗААХ

Багш, туслах багш, боловсролын мэргэжилтнүүд ангид болон цөөн сурагчтай бүлгээр эсвэл тухайн сурагчийн амжилт гаргахад хувь **нэмэр оруулах зорилготой төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр ганцаарчлан сурагчтай ажилладаг.** Зөвлөх, сэтгэцийн эрүүл мэндийн баг Нийгэмших, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх дэмжлэг, мэдээллийг өгнө.

### 4 ДҮГНЭХ

Багш нар сурагчийн ахицыг үнэлж, шаардлагатай бол төлөвлөгөөг шинэчлэхийн тулд тогтмол багаар хамтран ажилладаг. Сурагч бүр ахиц дэвшил гаргахад зориулж зохих дэмжлэгийг үзүүлэхийн тулд **тогтмол үнэлгээ, дүгнэлт хийх**